

## НЭЭЛТТЭЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

**Гэрээний нэр, дугаар:** МРЦТ/201803145

**Төслийн нэр, дугаар:** “Монголросцветмет” ХХК-ийн тээврийн хэрэгсэл, хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын даатгагч сонгон шалгаруулах”, МРЦТ/201803145

“Монголросцветмет” ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “Монголросцветмет” ХХК-ийн тээврийн хэрэгсэл, хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын даатгагч сонгон шалгаруулах” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын аль нэг жилийг борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Тусгай зөвшөөрлийн хуулбар**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлж болно.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын санхүүгийн тайланг аудитийн дүгнэлтийн хамт ирүүлнэ
- Хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж гүйцэтгэсэн байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн актыг хавсаргана.
- Тендерийн баталгаа.** Санал болгож үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 05 дугаар сарын 18** -ны өдрийн **15 цаг 00** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 15 цаг 50 минутанд нээнэ.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, “Монголросцветмет” ХХК, 507 тоот өрөө

**Утас:**450060-172, 450060-243, **Факс:** 458-380

**МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК**